



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн “Дагшин-Эрдэнэ” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/4/НА-СТА-ААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020

Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа

Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: domogovi@audit.gov.mn

2022.09.15 № 16/2022

танай _____-ны № _____-т

ДАГШИН-ЭРДЭНЭ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	174.4	103.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	393.5	381.1
	Нийт хөрөнгийн дүн	567.9	484.9
	Нийт өр төлбөрийн дүн	2.8	12.1
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	565.1	472.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	567.9	484.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	239.7	26.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	165.6	113.6
	Үйл ажиллагааны үр дүн	74.1	(87.5)
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.4	4.8
	Үйл ажиллагааны нийт үр дүн	73.7	(92.3)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,089.5	1,089.5
	Хуримтлагдсан үр дүн	(524.3)	(-616.6)
	Эцсийн үлдэгдэл	565.1	472.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	244.1	27.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	160.6	102.8
	Үйл ажиллагааны ЦМГ	83.5	(75.4)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19.7	103.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	103.2	27.8

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн “Дагшин-Эрдэнэ” ОНӨААТҮГ-ын зорилго нь үйлчлүүлэгчдээ дээдэлсэн, эелдэг найрсаг, чадварлаг хүний нөөцтэй, байгальд ээлтэй, бизнесийн таатай орчин бүрдсэн, өндөр чадавхи бүхий сувилал байж, өөрөө өөрийгөө бүрэн санхүүжүүлж ашигтай ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сувилалын мэргэжлийн үйл ажиллагаа
- Зочид буудал, амралтын газрын үйл ажиллагаа
- Байр орон сууц түрээслэх үйлчилгээ
- Ус хуримтлуулан түгээх цэг
- Халуун усны үйл ажиллагаа

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” статустай байна. Өмчийн 100 хувь орон нутгийн өмч байна.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тус байгууллагын хувьд шилэн дансны тухай хуулийн заалтуудыг зөрчсөн аливаа асуудал үүсээгүй болно.

3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 15.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 15.3 сая төгрөгийн алдааг залруулж, 2 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 15.3 сая төгрөгийн 5 алдааг залрууллаа. Үүнд:

- 2.9 сая төгрөгийн акталсан бараа материалыг үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн.
- 8.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй барилгын материалыг урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн.
- Барилга байгууламжийн ашиглалтын хугацааг буруу тооцсоноос 1.6 сая төгрөгийн элэгдэл зөрүүтэй тооцогдсон.
- 0.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталсны гарзыг дутуу бүртгэсэн.
- Зардалд төлсөн худалдан авалтын 1.3 сая төгрөгийн НӨАТ-ыг хасалгүйгээр борлуулалтын орлогыг өсгөж алдаатай бичилт хийсэн байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: 2021 онд аж ахуйн нэгж байгууллагуудаас и-баримтгүй 25.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-ийн тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 4.1.14-т "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр

[illegible]